MMINFO.

19 дэх жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,129.883... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2017.02.03. Баасан. №023 (4637) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР




УЛС ТӨР

МАЛЧДЫН АМЬЖИРГАА САЙЖРУУЛЖ, ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ ТӨСЛИЙГ ҮРГЭЛЖЛҮҮЛНЭ

II нүүрт

ДЭЛХИЙ

БНХАУ-ЫН ТЭРБУМТАН ХОНКОНГОД СУРАГГҮЙ АЛГА БОЛЛОО

IV нүүрт

Дугаарын 60 мөр

## Киноныхон ухамсартай бай л даа

Н.БАТЗАЯА

Гадаад киног хуулбарлаж болно, гэхдээ зөв зүйлийг нь... Яагаад ч юм сүүлийн үед энэ үгийг эрхэм кино уран бүтээлчдэд хандан хэлмээр санагдах боллоо. Кино урлаг гэдэг зугаацан цэнгүүлэхээс гадна соён гэгээрүүлэх, кино урлагаар дамжуулан үзэгчдийг сайн сайханд уриалан, ухаарал өгөх үүрэгтэй. Гэвч сүүлийн үеийн уран бүтээлчдийн хийж буй киноноос өсвөр насны хүүхдүүдийг буруу зүйлд уруу татсан зүйл ихээхэн ажиглагдах болж. Тодруулаад хэлбэл, кинондоо имиж бүрдүүлэх үүднээс элдэв янзын этгээд үг хэллэг, буруу зуршлыг харуулах нь ихэслээ. Хамгийн сүүлд л гэхэд “Милл” кино компанийн бүтээсэн “Приусын босс” киноны гол дүрийн эмэгтэй үзэгдэл болгон дээр тамхи татаж байх юм.

**Үргэлжлэл нь III нүүрт**

ҮЗЭЛ БОДОЛ

# ХЭН ЮУ ХЭЛЭВ

Э.ТУУЛ

*Өнгөрсөн долоо хоногт улс орны хэмжээнд олон үйл явдал болж өнгөрлөө. Тодруулбал, эрүүл мэндийн салбар болон байгаль орчны салбарт олон шийдвэр гарч, хэрэгжиж эхлэв. Мөн Монгол Улсын гавьяат эдийн засагч Б.Осоргарав хандивын аян санаачилж, иргэдээс цугласан хандиваар улсын өрийг төлөх тухай мэдээлэл цацагдав. Үүнээс гадна Шинэчлэлийн Засгийн газрын хэрэгжүүлсэн “Нүүрс” хөтөлбөрөөс мөнгө завшсан хэргээр Улсын дээд шүүхээс 3.6 жилийн хорих ялаар шийтгүүлсэн Л.Гансүхийн магадлангаар суллагдах хугацаа хэтэрсэн талаар түүний өмгөөлөгч мэдээлэл хийсэн юм. Тиймээс энэ удаагийн “Хэн юу хэлэв” булангаараа дээр үйл явдлын хүрээнд хэн ямар байр суурь илэрхийлснийг хүргэж байна.*

### А.Цогцэцэг: Улсын эмнэлгүүд хоёр ээлжээр 20:00 цаг хүртэл ажиллана

*/Эрүүл мэндийн сайд/*

Энэ сарын 01-ээс эмнэлгүүд хоёр ээлжээр ажиллах сайдын тушаал гарсан билээ. Энэ талаар Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэг “Эмнэлгийн тусламж үйлчилгээний ачааллыг бууруулах, хүлээгдлийг багасгах зорилгоор хоёрдугаар сарын 1-ний өдрөөс эхлэн Улсын нэгдүгээр төв эмнэлэг, П.Н.Шастины нэрэмжит Улсын гуравдугаар төв эмнэлэг, Хавдар судлалын үндэсний төв, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн ажиллах цагийг уртасгаж, 20:00 цаг хүртэл, зуны улиралд 21:00 цаг хүртэл, Бямба гарагт 10:00-15:00 цагийн хооронд ажиллуулахаар шийдвэрлээд байна. Харин Гэмтэл согог судлалын үндэсний төвийн амбулатори засвартай байгаа учир тус эмнэлэгт энэхүү шийдвэр ирэх гуравдугаар сарын нэгнээс эхэлж хэрэгжинэ. Энэ нь үйлчлүүлэгчдийн ачаалалтай холбогдуулан эмнэлэг хоёр ээлжээр ажиллаж байгаа нь ханиад томууны дэгдэлттэй хамааралгүй гэж ойлгож болно. Нэг эмчид ногдох үзлэгийн цаг гэж байдаг. Стандартаар бол нэг хүнийг 20 минутад үзэх ёстой.

Энэ хугацаанд эмч тухайн иргэний өвчтөний түүхийг маш сайн уншиж, өмнөх лабораторийн шинжилгээнүүдийг нь харьцуулах зэргээр анализ хийдэг. Гэтэл өнөөдөр манай эмч нар оочер дугаарлалтад хавчигдаад өвчтөнийг богино хугацаанд хурдан үзэх болчихоод байна. Энэ нь үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжид нөлөөлөх нөгөөтэйгүүр эрсдлийг бий болгох магадлалтай тул уг шийдвэрийг гаргаж байна. Ингэхээр иргэд энэ сарын 01-ээс эхлэн оройн 20:00 цаг хүртэл дээрх дөрвөн эмнэлгээр үйлчлүүлэх боломжтой гэсэн үг. Харин иргэд цаг авч авсан цагтаа ирж үзүүлэх нь зүйтэй. Мөн дээрх таван эмнэлэгт 40 их эмч, 203 сувилагч нэмж ажиллуулахаар ЭМС-н А/48 тоот тушаал гарлаа. Сайдын багцаас эмч нарын цалингийн асуудлыг шийдвэрлээд байна. Энэ хэмжээгээр ажлын байр бий болсон гэж ойлгож болно. Лабораториудын тухайд дүрс оношилгоо, рентген, эхо, компьютер, имрай, лабораториуд бүгд ээлжээ дагаад 20:00 цаг хүртэл ажиллана. Энэ бол байнга хэрэгжих шийдвэр. Өвчлөл багасаад үзүүлэх хүний тоо буурсан тохиолдолд шийдвэрийг эргэж харахад болохгүй гэх зүйлгүй. Тухайн үед нь өөрчилж болно” хэмээсэн юм.

**Үргэлжлэл нь III нүүрт**

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

## “Элэг бүтэн Монгол 2” хөтөлбөр ходоодны хорт хавдартай “дайтна”

Х.НОРЖИН

Хавдартай тэмцэх дэлхийн өдөр маргааш тохионо. Дэлхий дахинаа нэгдэн хорт хавдартай тэмцэж буй энэ цаг дор Монгол Улс ч гар хумхин суугаагүй билээ. Элэгний хорт хавдартай тэмцэх ажлыг Засгийн газраас дэмжиж, “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн нь энэ өвчнөөр шаналж байсан олон зуун хүнд амьдрал бэлэглэснийг уншигчид санаж байгаа биз ээ. Эдүгээ дэлхийн зах зээлд өндөр үнээр нийлүүлэгдэж буй элэгний В, С вирусын эсрэг эмийг зөвхөн Монгол Улс иргэддээ хөнгөлөлттэй үнээр нийлүүлж байгаа төдийгүй нийгмийн даатгалын багцад багтаах болсон тухай сайхан мэдээлэл цацагдаад удаагүй байна. Чухамдаа нийгмийн сайн сайхны төлөө авч хэрэгжүүлж буй эл арга хэмжээний үр дүнгийн цаана эмч, сэтгүүлчдийн хамтын зүтгэл оршиж буй талаар ХСҮТ-ийн дарга Ж.Чинбүрэн өчигдөр сэтгүүлчидтэй уулзах үеэрээ онцолсон. Тэрбээр “Би энэ удаад чадахын төлөө бус чадсан, амжилтад хүрсэн зүйлийнхээ талаар түрүүлж ярихыг хүсч байна” гээд “ХСҮТ-ийн өргөтгөлийн барилга тун удахгүй ашиглалтад орно. Аливаа зүйлд орчин бүрдэнэ гэдэг хамгийн чухал зүйл төдийгүй амжилтын үндэс. Эмнэлгээ өргөтгөхийн төлөө сэтгүүлч та бүхэнтэй хамтдаа зүтгэсэн. Бид чадсан, санасандаа хүрсэн. Түүнчлэн В, С вирусын эмийн үнийг ЭМД-аас хөнгөлж, 24 тэрбум төгрөг төсөвлөсөн. Хавдрын 40 хувийг дангаараа эзэлж буй элэгний өвчинтэй тэмцэхэд та бидний оруулсан бодит үр дүн энэ юм” хэмээсэн юм. Хавдартай тэмцэх өдрийг дэлхий нийтээр “Би чадна, бид чадна, та ч бас чадна” гэсэн уриан дор тэмдэглэх бөгөөд манай улсын хувьд “Ходоодны хавдартай тэмцэх жил” болгон зарлаж, “Элэг бүтэн Монгол 2” гэсэн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэхээр болжээ. Хүнсний аюулгүй байдал, хеликобактер, амьдралын буруу хэв маягаас үүдэн ходоодны шархтай, хавдартай болж буй хүний тоо жилээс жилд нэмэгдсээр байгаа аж. Тиймээс энэ сарын 18-нд ХСҮТ-ийн эмч нар БНСУ-ын эмч нартай хамтран ходоодны хорт хавдрыг эрт үед нь илрүүлэх, эмчлэх тал дээр хамтран ажиллах Санамж бичиг байгуулахаар болсон байна. “Элэг бүрэн Монгол-2” хөтөлбөр хэрэгжсэнээр олон зуун хүний амийг аврах нөхцөл бүрдэхээс гадна зөвхөн үзлэг, оношлогоо, мэс заслын төлбөрт гадагшаа урсдаг мөнгөний урсгалыг дотооддоо авч үлдэх нөхцөл бүрдэнэ хэмээн хөтөлбөр боловсруулагчид үзэж байгаа аж. Ж.Чинбүрэн эмчийн хэлсэн жишээгээр 2015 онд 11 сая ам.доллар гадагшаа урссан байх юм. Нөгөөтэйгүүр, нийгэмд эерэг мэдээлэл түгээх, эрүүл мэндээ хайрлан хамгаалах талаархи мессэжийг байн байн өгч байх нь хавдрыг эрт оношлоход ихээхэн үүрэг гүйцэтгэдэг учраас ХСҮТ-ийнхөн “Элэг бүтэн Монгол-2” хөтөлбөрийг хэвлэл мэдээллийнхэнтэй хамтран хэрэгжүүлэхийг чухалчилж байгаа юм байна. Тухайлбал, 2009 онд Ж.Чинбүрэн эмч элэгний жижиг хавдрыг түлэх эмчилгээг анх нэвтрүүлсэн бөгөөд тэр үед жилд ийм эмчилгээ хийлгэх 20 хүн олдоггүй байж. Өөрөөр хэлбэл, хавдраа эрт илрүүлж, бага дээр нь эмчид хандах хүн маш цөөн байсан гэсэн үг. Эдүгээ жилд 500 гаруй хүн дээрх эмчилгээг хийлгэх болжээ. Хавдрыг эрт илрүүлгийн сайн жишээ энэ юм. Гэвч жилд 2000 хүн элэгний хавдартай хэмээн оношлогдсоны 80 хувь нь хожуу үедээ эмчид ханджээ. Дашрамд өгүүлэхэд, хавдрыг эрт үед нь оншлуулах аваас бүрэн төгс эдгэрдэг өвчин гэж Ж.Чинбүрэн эмч онцолно билээ.




ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

## Д.БАТБАЯР: 2017 ОНД АВТОТЭЭВРИЙН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛНА




Н.БАТЗАЯА

Автотээврийн үндэсний төвийн удирдлага, мэргэжилтнүүдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх үндэсний зөвлөгөөн өчигдөр Автотээврийн үндэсний төвийн хурлын танхимд боллоо. Энэ жил “Автотээврийн менежментийг сайжруулах жил” болгон зарласантай холбогдуулан Улаанбаатар хот болон орон нутгийн удирдах ажилтнууд, нягтлан бодогч, техникийн хяналтын үзлэгийн инженерүүдийн мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, цаашид хийж гүйцэтгэх ажлаа танилцуулах зорилгоор энэхүү зөвлөгөөнийг зохион байгуулжээ.

**Үргэлжлэл нь IV нүүрт**

**ХААН банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2460.00 | 2484.00 | ФУНТ | 3071.00 | 3188.00 |
| ЕВРО | 2624.00 | 2704.00 | РУБЛЬ | 39.30 | 42.80 |
| ИЕН | 21.59 | 22.02 | ЮАНЬ | 358.00 | 364.40 |

**Худалдаа хөгжлийн банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2472.00 | 2484.00 | ФУНТ | 3101.00 | 3203.00 |
| ЕВРО | 2635.00 | 2723.00 | РУБЛЬ | 39.88 | 43.49 |
| ИЕН | 21.62 | 22.37 | ЮАНЬ | 359.00 | 364.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын 60 мөр

## Киноныхон ухамсартай бай л даа

**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**

Гаргах гэж байгаа дүр нь танхай, этгээд, эршүүд эмэгтэйн дүр байлаа гээд үзэгдэл бүр дээр тамхи татах нь үзэж байгаа хүмүүст, ялангуяа өсвөр насны охидод тамхи татвал "гоё" харагддаг гэх мессэжийг өгч байв. Ядаж байхад үзэгчдийн дийлэнх нь арван жилийн сурагчид байх юм. Тэр бүү хэл дөрөв, таван настай хүүхдүүд ч ээж, аавтайгаа хамт үзэж байх жишээтэй. Элдэв хараал, буруу зуршлыг сурталчилсан кино үүгээр дуусахгүй. 2015 онд "Уужим" фильм, F Студио, MIM Филмийн залуус "Хар сувдны нууц" хэмээх уран бүтээлээр үзэгчиддээ бэлэг барьсан. Харамсалтай нь киноны гол дүрийн жүжигчин Алтаншагай бас л алхам бүртээ "ш...сан" гээд л байх нь тэр. Ямар сайндаа л найзын минь дөрвөн настай хүү "Хар сувдны нууц" киног үзсэнийхээ дараа "ш...сан" гэж хэлээд зогсож байх вэ дээ. Жүжигчин Алтаншагайгийн энэ үг нэг хэсэгтээ л арван жилийн сурагчдын дунд трэнд болсон гэхэд болно. Өсвөр насны охид, хөвгүүд хоорондоо сайн, муу зүйл ярьсан ч өнөөх үгийг зүгээр л нэг үг шиг хэлж, нэг их гоё үг хэлсэн юм шиг инээлдэж байх. Энэ талаар цахим ертөнцөд нэг хэсэгтээ л хэлэлцүүлэг өрнөсөн. Одоо тэгвэл энэ байдлыг үүсгэхэд хэн нөлөө үзүүлсэн бэ гэдэг асуулт өөрийн эрхгүй гарч ирнэ. Харин миний бие өсвөр насныхан болон залуучуудын сэтгэхүй, биеэ авч явах байдал, харилцааны соёлд кино урлаг шууд нөлөө үзүүлж байна гэж хэлнэ. Мөн онд "Ахан дүүсийн нэгдэл" /BrotherHood/-ийн залуус хамтран "Том Толгойтын Романс" хэмээх нэгэн дэлгэцийн уран бүтээл хийсэн. Тус кино үзэгчдийн зүгээс нэлээд сайшаал хүртсэн хэдий ч тус киноны туслах дүрийг бүтээсэн Ганбаа "п..."-г ч ёстой урсгадаг. Энэ мэтчилэн элдэв хараалын үг урсгаж өгдөг киног сүүлийн үед их хийх болжээ. Сүүлдээ уран бүтээлчид кино хийгээд байна уу аль эсвэл дэлгэцийн урлагаар дамжуулан хараалын үг, хэллэгийг олон нийтэд сурталчлаад байна уу гэдэгт эргэлзэх болов. Ингээд хэлэхээр гадаадын кинон дээр ч гэсэн амаа хамхи, өлөгчин, чөтгөр аваг гэж хэлдэг биз дээ, юун сүртэй юм хэмээн өмөөрөх нэгэн байгаа байх. Гэхдээ Холливудын кинонуудаас хуулбарлах өөр зүйл олон байна шүү дээ. Өнгө дүрс, дуу хөгжим, зохиолын шинэ санаа гээд хуулбарлах олон зүйлс байна. Яах вэ, хуулбарлаж болно, гэхдээ хараалын үгийг л биш шүү уран бүтээлчид ээ. Кино театрууд үзвэрээ насны ангилалгүй үзүүлж байгааг, кино танхимд дөрвөн настай балчираас эхлээд 60 настай буурал хүртэл хамт суугаад киног чинь үзэж байгааг анхаарах л хэрэгтэй. Тэгээд ч манай ард түмэн туйлшрамтгай. Охид, залуучууд бие биеэ дуурайх дуртай байдаг. Тэр дундаа шүтэн биширдэг жүжигчин, дуучдынхаа алхам бүрийг харж, үлгэр дуурайл ч авах нь бий. Нийгмийн огт өөр хандлагатай оронд уран бүтээл туурвиж байж харийн орны хараалын үгээр киноныхоо имижийг бүрдүүлдэг болхидуухан аргыг хуулбарлаад ч яах вэ дээ. Ямартай ч, уран бүтээлчид энэ тал дээр анхаарахгүй бол арван жилийн сурагчдын хэл ам гүйцэгдэхээ болилоо. Гадаадын киноноос хуулбарлаж болно, гэхдээ хараалын үгийг лав биш шүү кино уран бүтээлчид ээ.

# ХЭН ЮУ ХЭЛЭВ









**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**

### Д.Оюунхорол: Байгууллага, иргэдийн хамтын оролцоотойгоор бид утаанаасаа салж чадна

*/Байгаль орчин, аялал жуулчлалын сайд/*

Иргэд өөрсдийн эзэмшлийн приус машинаар агаарын бохирдол ихтэй бүсүүдэд эргүүл хийж, ард иргэдэд ухуулга сурталчилгаа хийх ажлыг өчигдрөөс эхлүүллээ. "Цэвэр агаар-иргэн миний үүрэг оролцоо" сэдэвт төслийн хүрээнд энэхүү ажлыг хэрэгжүүлж буй бөгөөд БОАЖЯ, Монголын байгаль орчны иргэний зөвлөл / МБОИЗ/ хамтран хэрэгжүүлж байгаа юм. БОАЖ-ын сайд Д.Оюунхорол үйл ажиллагааг нээж хэлсэн үгэндээ "БОАЖЯ-аас "Агаарын бохирдлыг бууруулахад - Иргэн таны оролцоо" аяныг нэгдүгээр сарын 01-нээс эхлүүлсэн. Энэ аяны хүрээнд бид ард иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, санал санаачилгыг дэмжсэн зарим ажлыг хийж байна. Тухайлбал, гэр хорооллын шөнийн цахилгааны үнийг тэглэсэнтэй холбоотойгоор "Утаа бууруулах техник, технологийн үзэсгэлэн"-г энэ сарын 09-10-нд зохион байгуулсан. Утаатай тэмцэх дадал хэвшлийг хэвшүүлэх сурталчилгааны ажлыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хийж байна. Эмнэлгүүдэд шаардлагатай агаар цэвэршүүлэгч шүүлтүүрийг олон нийтийн дэмжлэг, хандиваар цуглуулж өгч байгаа "Бяцхан агаар" нийтийн санхүүжилтийн аянд БОАЖЯ-ныхан нэг өдрийн цалингаа хандивлалаа. Цаашдаа нийслэлийн гурван дүүрэгт утааг бууруулах техник технологийн үзэсгэлэнг дахин зохион байгуулна. Төр засгаас агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр гаргаж байгаа бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх үүрэг нь иргэдэд бий. Тиймээс төр, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн хамтын оролцоотойгоор бид утаанаасаа салж чадна" хэмээв. Мөн МБОИЗ-ийн тэргүүн Б.Эрдэнэ "Агаарын бохирдлыг бууруулахад олон нийт, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор энэхүү төслийг хэрэгжүүлж эхэллээ.Иргэн хүн агаарынбохирдлыгбууруулахад миний хийх үүрэг оролцоо юу байх вэ гэдгийг ухамсарлаж чадсанаар бид хамтдаа утаагаа бууруулж чадна. Олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх нөлөөллийн ажил өөр өөр арга хэлбэрээр явна. Энэ удаагийн хөдөлгөөнт эргүүлийн гол зорилго нь иргэд агаарын бохирдлыг бууруулахад юу хийх вэ, бидний үүрэг оролцоо юу байх вэ гэдгийг ойлгуулах, сурталчлахадголлложажиллана" гэлээ. Хөдөлгөөнт эргүүл хийх 64 хүнтэй баг зургаан дүүрэгт, хэсгийн дарга нартай хамтран ажиллах бөгөөд зайлшгүй дэмжлэг үзүүлэх айл өрхүүдийн талаар тандалт хийж боломжит дэмжлэгийг нэгээхэн хэсэгт нь хүргэх, иргэд нэг нэгэндээ хяналт, шаардлага, тавих эрүүл аюулгүй амьдрах эрхээ хэрэгжүүлэхэд иргэдийн үүрэг, оролцоо нэмэгдүүлэх, амьдралын дадал хандлагыг өөрчлөхөд нөлөөлөх, иргэний ухамсарыг сэргээхэд иргэний нийгмийн үүрэг оролцоо нөлөөллийг өргөжүүлэх, олон нийтийг уриалах ажлыг хийх ажээ. Энэ үеэр хөдөлгөөнт эргүүлийн багт ажиллахаар болсон найман идэвхитэн байгаль хамгаалагчид байгаль хамгаалагчийн үнэмлэх гардуулсан юм.

### Ж.Эрдэнэбат: Иргэдийн хандивыг бондын өр төлөхөд зарцуулахгүй

*/Монгол Улсын Ерөнхий сайд/*

Монгол Улсын гавьяат эдийн засагч Б.Осоргарав хандивын аян санаачилсан билээ. Үүнийг нь Засгийн газрын захиалга, төр иргэдээсээ хандив авч бондын өрөө төлөх гэж байгаа мэтээр шуугиж буй. Тэгвэл үүнтэй холбогдуулж Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат байр сууриа илэрхийлж, зарим сайд нарт үүрэг өгчээ. Тэрбээр "Хандив бол иргэдийн сайн дурын аян. Засгийн газар ийм аяныг эхлүүл гэж хэлээгүйтэй адил иргэдийнхээ сайн дурын санаачилгыг зогсоо гэж үүрэгдэх боломжгүй. Эх орноо гэж байгаа сайхан сэтгэлтэй хүнийг, түүний үйлдлийг ч цааш түлхэж болохгүй. Тийм учраас Төрийн сан дээр хандивын нэгдсэн данс нээ. Хандив хүлээж авах тодорхой хугацаа тогтоож, энэ хугацаанд ирсэн орлого, хандивыг өдөр бүр олон нийтэд ил тод мэдээлж байхыг Сангийн сайд Б.Чойжилсүрэнд үүрэг болгож байна. Гэхдээ Монголын төр, Засгийн газар ард түмнээсээ хандив цуглуулж бондын өр төлөхгүй. Иргэдийн хандиваас нэг ч төгрөгийг бондын өр төлөлтөд зарцуулахгүй. Засгийн газар ирэх гуравдугаар сард төлөх бондын өрөө хэрхэн төлөх шийдлээ нэгэнт олсон, хугацаанд нь бүрэн төлөх боломжтой болсон байгаа. Харин иргэдээс сайн дурын үндсэн дээр цугларсан хандивыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж байгаад эрүүл мэнд, боловсрол, нийслэлийн утааг бууруулах, дэд бүтцийн шинэчлэл зэрэгт ард түмнийхээ хяналт дор зарцуулна" хэмээгээд эх оронч санаачилга эхлүүлсэн, үүнд нэгдсэн иргэдэд Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс албан ёсоор талархал илэрхийлэх, хандивын аянд оролцсоныг нотлох батламж хадгалуулах зэргээр тухайн иргэдийг алдаршуулахыг холбогдох сайд нарт үүрэг болголоо. Дашрамд дурьдахад Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат өчигдөр /1 сарын 31-нд/ хандивын аян санаачлагч Б.Осоргаравыг өөрийнх нь хүсэлтээр хүлээн авч уулзахдаа "Таны эх оронч сэтгэлийг хүндэлж байна. Гэхдээ Засгийн газар ард түмнээсээ хандив авахгүйгээр бондын өрөө ч төлнө, эдийн засгийн хямралаа ч давна, тийм бололцоо бүрэн байгаа" гэдгээ тодорхой хэлсэн юм.

### Л.Гансүх: Эрх чөлөөтэй болох гэж яарсандаа биш хорт хавдартай эхнэрээ эмчлүүлж, асрах гэж хоног тоолон сууна

*/Ерөнхий сайд асан Н.Алтанхуягийн ахлах зөвлөх асан/*

Шинэчлэлийн Засгийн газрын хэрэгжүүлсэн "Нүүрс" хөтөлбөрөөс мөнгө завшсан хэргээр Улсын дээд шүүхээс 3.6 жилийн хорих ялаар шийтгүүлсэн Л.Гансүхийн магадлангаар суллагдах хугацаа хэтэрчээ. Учир нь, хүндэвтэр ялтай хүмүүс хоригдох хугацаандаа элдэв зөрчил гаргалгүй, учруулсан хохирлоо барагдуулж, оноосон ялын хоёрны нэгийг биечлэн эдэлсэн тохиолдолд хугацаанаасаа өмнө суллагдах эрх хуулиар нээгддэг байна. Тэгвэл Л.Гансүхийн хувьд 2016 оны арваннэгдүгээр сард магадлангаар суллагдах шаардлагыг хангажээ. Гэвч түүнийг суллах хүсэлтийг хоёр удаа Төв аймгийн Мөнгөнморьт дахь Хорих ангиас прокурор руу илгээсэн боловч авч хэлэлцээгүй байна. Энэ талаар Л.Гансүхийн өмгөөлөгч Ц.Баасандорж "Төв аймгийн прокурор ямар үндэслэлээр Л.Гансүхийн материалыг шүүх рүү явуулахгүй байгааг гайхаж байна. Прокурорын байгууллага Л.Гансүхтэй хамт хоригдсон олон хүнийг магадлангаар сулласан. Тэр ч бүү хэл хүн амины хэрэгтэй, бага насны хүүхэд хүчирхийлсэн хэрэгтэн хүртэл суллагдсан байгаа. Тэгсэн хэрнээ Л.Гансүхийг ганцааранг нь суллахгүй байгаа юм. Хуулиараа прокуророос ялтны материалыг хорих руу нь буцаах үндэслэл байхгүй. Прокурор дамжуулагчийн үүрэг гүйцэтгэж, шүүх рүү шилжүүлэх ёстой. Л.Гансүхийн биеийн байдал ч сайнгүй байгаа. Өөрөөс нь илүүтэй эхнэр нь их тааруу байна" гэв. Тэрбээр өчигдөр Төв аймгийн прокурортой уулзаж, учир шалтгааныг тодруулахаар явж байгаа юм байна. Үүний дараа Улсын Ерөнхий прокурорт хандаж, энэ асуудал Төв аймгийн прокурортой холбоотой байна уу эсвэл өөр хүн нөлөөлөөд байна уу гэдгийг тодруулах аж. Мөн Л.Гансүхийг бусад ялтнуудтай адилхан хуулийн дагуу суллах хүсэлт гаргах юм байна. Түүнчлэн Л.Гансүх хорих ангиас нь суллагдах хүсэлт нь тодорхойгүй болсонтой холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчид захидал илгээжээ. Уг захидалдаа "Таны захиалгаар, таны томилдог АТГ, прокурор, шүүхийн тодорхой бүлэг хүмүүсийн хилс хэрэг зохион байгуулан байж надад тохсон ялыг чинь өнгөрсөн оны арваннэгдүгээр сард эдлээд дууссан. Эрүүгийн хуулийн 74 дүгээр зүйлийн үндэслэн биеэр эдлэх ялын холбогдох хугацааг дуусгасан, өр төлбөргүй, хэрэг зөрчил ял эдлэх хугацаандаа гаргаагүй учраас хуулийн дагуу Төв аймгийн прокурор руу хорих ангиас 2016 оны арванхоёрдугаар сар, 2017 оны нэгдүгээр сард нийт хоёр удаа материал явуулсан боловч миний материалыг шүүх рүү явуулалгүй үндэслэлгүй хорьж байна. Хэрэг хийгээгүй байж танай хуулийн мафийн өгсөн ялыг эдэлж суухдаа эрх чөлөөтэй болохдоо яарсан биш хорт хавдартай үлдсэн эхнэрээ хурдан гарч эмчлүүлж, асарч сувилах юмсан гэж хоног тоолон суулаа. Таны хугацаа дуусахад хэдхэн сар дутуу боловч нэг өдрийн өмнө ч гэсэн прокурор, хууль, хүчний байгууллагаас савраа татаж, хуулийг гууль болгохоо зогсоож, миний Үндсэн хууль, Эрүүгийн хуулиар олгогдсон эрхийг эдлүүлэхийг хүсье. Шоронд юу ч хийж чадахгүй байж байгаад эхнэрээ алдвал шударга бус зүйлийг чинь засахын төлөө бидний амь хэрэгтэй бол ав гэж хэлье" гэжээ.

## ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ




Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

# ДЭЛХИЙ



# БНХАУ-ЫН ТЭРБУМТАН ЭР ХОНКОНГОД СУРАГГҮЙ АЛГА БОЛЛОО

Б.ДАВААХҮҮ

Хилийн чанад дахь Хятад хэлээр гардаг зарим хэвлэлд БНХАУ-ын тэрбумтан Сиао Жианхуа өнгөрсөн долоо хоногт Хонконгод байхдаа сураггүй алга болсон тухай мэдээлэл нийтлэгджээ. Гэхдээ тэрбумаар тоологдох хөрөнгө бүхий эр зүгээр ч нэг алга болоогүй бололтой. Түүнийг аюулгүйн албаныхан хулгайлсан байх магадлалтай гэнэ.

Учир нь энэ сарын 1-ний Хонконгийн нэгэн сонинд тэрбумтны нэрээр БНХАУ-ын Засгийн газарт хандан үнэнч байхаа тангарагласан утга бүхий мэдэгдэл нийтлэгдсэн байх бөгөөд түүнд Сиао Жианхуагийн сураггүй алга болсонтой холбоотой байх магадлал бүхий нууцлаг мэдээлэл гарсан байжээ. Томоохон хөрөнгө оруулагч, БНХАУ-ын хамгийн баян эрхмүүдийн нэг гэдгээрээ дэлхий дахинаа танигдсан тэрбээр сураггүй алга болохынхоо өмнө Хонконгийн “Дөрвөн улирал” гэх тансаг зэрэглэлийн зочид буудалд байрлаж байсан аж. Түүнчлэн, голдуу эмэгтэй хамгаалагчид тэрбумтныг хамгаалдаг байсан бөгөөд хамгийн сүүлд Хятадын аюулгүйн албаныхан тус зочид буудлаас Сиао Жианхуаг дагуулан авч явжээ. Улмаар түүнээс хойш сураг тасарсан гэнэ. Одоогоор тэрбээр хаана байгаа нь тодорхойгүй байгаа аж. Хэдийгээр гэр бүлийнхэн нь эрлийн ажиллагааг зогсоохыг хүссэн ч, тэрбумтны сураггүй болсон дуулиантай холбоотой хэд хэдэн сонирхол татсан учир битүүлэг зүйлс олон байгааг зарим хэвлэл онцолж байна. Тодруулбал, Сиаогийн тэргүүлэх Бээжинд төвтэй “Томорроу Холдинг” компани захирал нь алга болсны дараа “wechat” хуудастаа хачирхалтай мэдэгдэл гаргасан байжээ. Тэд эхлээд “Би Сиао Жианхуа хилийн чанадад эмчилгээ хийлгэж байна. Бүх зүйл сайн байгаа. Компанийн ажил хэвийн явагдаж байна” гэсэн мэдэгдэл гаргасан бол удалгүй “Ноён Сиао эх оронч хүн. Коммунист намыг тууштай дэмжигч” гэсэн мэдэгдэл гаргасан байх юм. Гэхдээ дээрх хоёр мэдэгдлийг удалгүй устгаж, дараахан нь хуудсыг ажиллагаагүй болгожээ. Тийм ч учраас Сиао Жианхуаг Хятадад шалгагдаж байгаагаас зайлахгүй гэж олон нийт таамаглаж байна. Мөн нэг сонирхолтой зүйл нь эрэн сурвалжлах чиглэлээр дагнан бичдэг “Минг Пао” сонинд “БНХАУ-ын Коммунист нам болон улстөрчдөд үнэнч байсаар ирсэн” гэх Сиаогийн мэдэгдэл нэг бүтэн нүүрэнд нийтлэгдсэн байсны зэрэгцээ өөрөө тун удахгүй хэвлэл мэдээллийн өмнө гарахаа илэрхийлсэн байжээ. Мөн тэрбээр “БНХАУ-д төвтэй байгууллага нь хуулийн хууль журмын дагуу үйл ажиллагаа явуулж ирсэн” гэсэн байсны зэрэгцээ “Би хулгайлагдаагүй” гэдгээ онцлон тэмдэглэжээ. Канадын иргэншилтэй гэдгээ ч мөн хүлээсэн байх аж. Санхүүгийн салбарт бизнес эрхэлдэг түүнийг Хятадад авлигын хэргээр шалгагдахаас зугтааж, Хонконгт амьдрах болсон гэлцдэг аж. Тэрбээр Хятадын эх газарт төрж өссөн боловч, Канадын иргэншилтэй бөгөөд Хонконгт байнга оршин суух эрхтэй юм байна. Тиймээс Канад болон Хонконгийн аль алиных нь хуулийн хамгаалалт түүнд үйлчилнэ. Гэтэл Хятадын тал “Нэг улс, хоёр систем” гэсэн бодлогоо зөрчиж, түүнийг хулгайлан авч явсан бол хууль зөрчсөн болж таарна хэмээн ажиглагчид хэлж байна. Өөрөөр хэлбэл, Хонконгод БНХАУ-ын аюулгүйн албаныхан мөрдөн шалгалт, баривчилгаа явуулах эрхгүй байна. Гэхдээ хоёр жилийн өмнө буюу 2015 онд Хятадын Засгийн газрыг шүүмжилсэн агуулгатай ном бүтээх ажилд оролцож байсан хэвлэлийн компанийн таван ажилтанг тус улсын аюулгүйн албаныхан хулгайгаар баривчилж, тухайн үедээ л шуугиан тарьж байжээ. Ямартай ч, асуудал эдүгээ тодорхойгүй байгаа ч, тэрбумтан Сиаог ч Хятадын тал хулгайгаар баривчилсан байх магадлал өндөртэй байгааг эх сурвалжууд онцоллоо.



## Трампыг эсэргүүцэгчид сургуулийн барилгыг галдан шатаажээ

АНУ-ын Калифорни мужийн Беркли дэх Берклийн сургууль энэ сарын 1-ний өдрийн шөнө шатжээ. Тухайн үед АНУ-ын шинэ Ерөнхийлөгчийн бодлого шийдвэрийг эсэргүүцэн жагсаал зохион байгуулж байсан иргэдийн тэмцэл хурцдаж, уурссан зарим нь сургуулийн барилгад гал тавьжээ. Түүнчлэн, цонхны шилнүүдийг нь хүртэл хагалж танхайрсан гэнэ. Жагсагчид иймхүү тус сургуулийг сонгон тэмцлийн хурц хэлбэрийг сонгосон нь ч учиртай аж. Тус сургуульд Трампыг дэмжигч консерватив “Breitbart News” агентлагийн удирдлага илтгэл тавихаар төлөвлөсөн байжээ. Гэвч Трампыг эсэргүүцэгчид жагссаны улмаас лекцийг цуцалсан байна. Энэ удаагийн эсэргүүцлийн жагсаал 1000 гаруй хүн оролцжээ. Тэд шинэ Ерөнхийлөгчийн бодлого шийдвэрийг эсэргүүцэж буйгаа илэрхийлэн хашгирч, барилга руу галтай лонх шидэж байсан гэнэ. Харин цагдаагийнхан оюутны хотхоныг хаасан байжээ. Ямартай ч, одоогоор хүн гэмтсэн гэх мэдээлэл байхгүй байна. “Breitbart News” агентлагийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан Стивен Бэннон Доналд Трампын ойрын хүн байсан бөгөөд эдүгээ томорч Ерөнхийлөгчийн Стратеги бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах зөвлөхөөр томилогдон ажиллах болсон билээ. Дэлхий дахиныг цочиролд оруулсан лалын шашинт долоон орны иргэдийг улс руу түр хугацаанд нэвтрүүлэхгүй байх Ерөнхийлөгчийн зарлигийг С.Бэннон санаачилсан гэдэг.

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

# Д.БАТБАЯР: 2017 ОНД АВТОТЭЭВРИЙН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛНА




**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Тус зөвлөгөөнд Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, дэд сайд Б.Цогтгэрэл, Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын захирал П.Дэлгэрнаран болон нийслэл, хөдөө орон нутгийн Автотээврийн төвийн дарга, нятлан бодогч, техникийн хяналтын үзлэгийн инженер зэрэг 150 гаруй хүн оролцон, автотээврийн салбарт тулгамдаж буй хүндрэл бэрхшээлүүд, түүнийг шийдвэрлэх арга замын талаар санал солилцсон юм. Зөвлөгөөний үеэр Чанарын удирдлагын албаны дарга Н.Зориг “Манай Автотээврийн үндэсний төв Монгол Улсын хэмжээнд автотээврийн бүх үйл ажиллагааг зохицуулдаг. Манайх Улаанбаатар хотод тав, 21 аймагт 22 салбартай. 2017 оныг тээврийн менежментийг сайжруулах жил болгон зарласан. Үүнтэй холбогдуулан орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа тээврийн төвүүдийнхээ удирдлага, инженер техникийн ажилтнуудтай уулзалт зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, цаашид хийх ажлаа төлөвлөж байна. Ер нь энэхүү үйл ажиллагааг жил бүр зохион байгуулдаг гэж хэлж болно. Манай төв тээвэр зохицуулалтын ажлыг орон нутагт хийж байна. Мөн улс хоорондын тээвэр зохицуулалтын ажлыг хийж байна. Энэ жил бид улс хоорондын тээвэр зохицуулалт дээр хоногийн нэгдсэн график нэвтрүүлэх гээд ажиллаж байна. Таван толгойгоос гарч байгаа нүүрсийг тээвэрлэх тал дээр зохицуулалтын арга хэмжээ авч ажиллаж байгаа. Тээврийн менежментийг сайжруулна гэхээр зөвхөн тээвэрлэлт гэж ойлгож болохгүй. Тээвэртэй холбоотой бүх үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх үйл ажиллагаа явагдах юм. Тиймээс бид автотээврийн зарим үйл ажиллагааг олон улсын стандартын шаардлагын дагуу итгэмжлэх, чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ажлыг хийж явж байгаа” гэв. Тус зөвлөгөөнөөр орон нутагт автотээврийн ажил үйлчилгээг хариуцан гүйцэтгэхдээ тухайн аймгийн Засаг даргатай гэрээ байгуулж, ажиллах, улс, хот хоорондын болон аймаг, орон нутгийн ачаа, зорчигч тээврийн ажил үйлчилгээнд тавих төрийн хяналтыг Зам, тээврийн хөгжлийн яамтай байгуулсан гэрээний дагуу хэрэгжүүлэх, автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох үйлчилгээг цахимжуулах, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд түргэн шуурхай үйлчлэх зэрэг чиглэлийн хүрээнд ярилцсан юм.

*Энэ үеэр Тээвэр зохицуулалтын хэлтсийн дарга Д.Батбаяртай цөөн хором ярилцлаа.*

**-Зорчигч, ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх тал дээр ямар арга хэмжээ авч байна вэ?**

-Манай Автотээврийн үндэсний төв 2017 оныг тээврийн менежментийг сайжруулах жил болгосон. Үүнтэй холбогдуулан манай төв дээр хэд хэдэн ажил хийгдэж эхэлсэн. Тухайлбал, 2016 оны долдугаар сард гурван улсын дамжин өнгөрөх тээврийг туршилтаар явуулсан. Энэхүү дамжин өнгөрөх тээврийн үйл ажиллагаа маань 2017-2018 оноос эхлэн хэрэгжинэ. Мөн холимог тээврийн үйл ажиллагааг туршилтаар явуулсан. Тээврийнхээ бусад төрлүүдтэй хамтраад зорчигч тээврийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй үзүүлэхийн тулд холимог тээврийн туршилтыг явууллаа. Өөрөөр хэлбэл, Улаанбаатараас Сэлэнгэ хүртэл галт тэргээр яваад Сэлэнгийн төвөөс Улан-Үд хүртэл улс хоорондын автобусаар явах юм. Энэ маань иргэдэд чирэгдэл учруулахгүй, хаалганаас хаалганд хүргэсэн үйлчилгээ болж чадсан. Холимог тээврийн үйлчилгээг 2017 оны хоёрдугаар сараас тогтмол явуулахаар төлөвлөж байгаа. Орос, Монголын автотээврийн хэлэлцээрээр чиглэлийг тохирсон. Дараагийн нэг чиглэл гэвэл Улаанбаатараас Манжуур хүртэлх тээврийн үйл ажиллагааг холимог тээврийн үйлчилгээгээр явуулахаар төлөвлөж байна. Ингэхдээ Улаанбаатараас Дорнод хүртэл онгоцоор ниснэ. Чойбалсангаас улс хоорондын автобусаар Манжуур хүрэх тээвэрлэлтийг энэ оны эхний улиралд явуулахаар төлөвлөж байна.

**-Онлайнаар тасалбар бичих үйл ажиллагааг туршсан. Энэ үйлчилгээ хэр үр дүнтэй хэрэгжиж байна вэ?**

-Бид 2015 оноос эхлэн онлайнаар тасалбар бичих ажлыг хийж байна. 2017 онд тасалбар бичилтийн үйл ажиллагааны нэлээдгүй хувийг онлайнаар бичих төлөвлөгөөтэй байгаа. Өнгөрсөн онд 160-аад сая төгрөгийн борлуулалтыг хийллээ. Мөн бид тасалбар бичилтийг гараар биш автомат машинаас бичихээр төлөвлөөд туршилтын ажил хийгдэж байна. Төрийн үйлчилгээний машинаас автотээврийн үйлчилгээний бүх лавлагаа, тасалбараа захиалах боломжтой.

## №12

## ßÏÎÍÄ ÑÓÓÃÀÀ ÌÎÍÃÎË×ÓÓÄ × ÒÝÒÃÝÂÐÈÉÍ ÄÀÀÒÃÀËÛÍ ØÈÌÒÃÝË ÒªËÄªÃ

Манай сонин долоо хоног бүрийн баасан гарагт нийгмийн даатгалын үйлчилгээ, түүний түгээмэл асуулт хариултын буланг Японы олон улсын хамтын ажиллагааны талаархи байгууллага /ЖАЙКА/-ын Монгол Улсад хэрэгжүүлж буй Нийгмийн даатгалын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх төслийн мэргэжилтнүүдтэй хамтран бэлтгэн хүргэж байгаа билээ. Уншигчдын төдийлөн мэддэггүй ч, заавал мэдэж байх ёстой, мөн манай улсын нийгмийн даатгалын тогтолцоонд тусгаж болохуйц түгээмэл асуултад Нийгмийн даатгалын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх төслийн ахлах зөвлөх Ямашита Мамору хариулж байна.



**-Японд сурч, хөдөлмөрлөж буй монголчууд тус улсын тэтгэврийн даатгалд хамрагдсанаар ямар давуу талтай вэ?**

-Японы Нийгмийн даатгалын системд үндэс угсаа, уг гарвал харгалзахгүйгээр Японд амьдарч буй бүх хүн хамрагдах үүрэгтэй байдаг. Японы аль нэг их, дээд сургуульд сурч буй 20-оос дээш насны оюутан, ажил хөдөлмөр эрхэлж буй монголчууд ч гэсэн шимтгэл төлөх ёстой. Шалтгаан нь юу юм бол гэж та бодож байна уу. Тэтгэврийн тогтолцоо гэдэг зөвхөн өндөр настнуудад зориулсан тэтгэмж биш. Японд оршин суух хугацаанд ямар нэг байдлаар өвдөх, гэмтэж бэртэх, бүр муугаар бодоход нас барсан үед таны төлсөн шимтгэл орлогын тань баталгаа болж, тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр хэлбэрээр олгогддог юм. Тэгэхээр ямар нэг хэлбэрээр шаардлага гарсан үед тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр авахын тулд Японд амьдарч буй бүх хүн нийгмийн даатгалын шимтгэл төлөх үүрэгтэй байдаг. Өвдөх, гэмтэж бэртэх гэх мэт аливаа эрсдэл ганц японччуудад бус, бүх хүнд л тохиолдоно шүү дээ. Тийм учраас аль улсын иргэн байхаас үл хамааран, Японд амьдарч буй хүн бүр эрсдэлээс хамгаалагдах давуу талтай гэж ойлгох хэрэгтэй. Түүнчлэн, тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах нөхцөл байдалтай тулгарлаа гэж бодоход япон хүмүүстэй яг ижил хэмжээний тэтгэмж авдаг юм. Нийгмийн даатгалын шимтгэл төлөх “үүргээ” биелүүлснээр тэтгэвэр, тэтгэмж авах “эрх” нь нээгдэх нь угтаа мэдээжийн хэрэг. Бас шимтгэлээ зөвхөн Японы банкинд бус, хилийн чанадад байгаа аль ч банкнаас төлж болдог. Өөрөөр хэлбэл, Монгол дахь банкны данснаасаа ч шилжүүлэх боломжтой гэсэн үг.



"ЧЕЛСИ"-ГИЙН БҮДРЭЛТИЙГ НЭХЭГЧИД АШИГЛАЖ ЧАДСАНГҮЙ

VI нүүрт

ГРИЗМАНН "ЮНАЙТЕД"-ТАЙ ЖИЛИЙН 17.7 САЯ ЕВРОГИЙН ЦАЛИНТАЙ ГЭРЭЭ ХИЙХЭЭР ТОХИРОЛЦЖЭЭ

VI нүүрт

АМЖИЛТЫН ЭЗЭН



# Б.СУМЪЯА:

## Амжилтын төлөө энэ спортоор хичээллэж байгаа учир гаднаас санал ирвэл би явна

Н.ПУНЦАГБОЛД

Залуучуудын өвлийн олимпийн аварга, Монголын шилдэг залуу тамирчдын нэг Б.Сумъяатай ярилцлаа. Тэрбээр нэгдүгээр сарын сүүлчээр болсон тэшүүрийн улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож, шилдэг тамирчин болохоо баталсан билээ.

**Төгсгөл нь VII нүүрт**

*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## Монголын хоккейчид Азийн наадамд оролцоно



*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

Шведэд болсон бөмбөгтэй хоккейн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд өрсөлдсөн манай баг тамирчид өнгөрсөн лхагва гарагт эх орондоо ирсэн билээ. Тус тэмцээний "В" ангилалд 10 орон өрсөлдсөнөөс Канад түрүүлж, Унгар, Монголын баг мөнгө, хүрэл медалийг хүртсэн юм. Анх удаа өвлийн спортын багийн төрлөөр хүрэл медалийг эх орондоо авчирсан баг тамирчдыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, БТСГ-ын дарга Ц.Шаравжамц ирсэн өдөр нь хүлээн авч уулзсан. Энэ үеэр Монголын хоккейн шигшээ багийг энэ сарын 19-26-ны өдрүүдэд Японы Саппоро хотноо болох Азийн өвлийн VII наадамд оролцох болсныг дуулгаж, бүхий л талаар дэмжихээ хэллээ. Бөмбөгтэй хоккейн ДАШТ-ийн "А" ангилалд ОХУ, Швед, Финлянд, АНУ, Герман, Норвеги, Беларус, Казахстаны багууд өрсөлдөж байна. Харин "В" ангилалд Канад, БНХАУ, Чех, Унгар, Япон, Монгол зэрэг арван орон багтсан юм. Манай хоккейчид 2006 оноос эхлэн тус тэмцээнд оролцсон бөгөөд өнгөрсөн жил шагналт IV байрт орж байсан.

## Я.Зоригтбаатар улсын рекордыг шинэчиллээ



Дэлхийн оюутны өвлийн "Универсиад 2017" наадам Казахстаны Алмата хотноо үргэлжилж байна. XVIII дахь удаагийн наадамд Монголын тамирчид тэшүүр, гүйлтийн цаны төрлөөр оролцож буй. Тэшүүрийн 500 метрийн эрэгтэйчүүдийн тэмцээн өнгөрсөн лхагва гарагт боллоо. Энэ ангилалд өрсөлдсөн Я.Зоригтбаатар 37.06 секундын амжилтаар 27 дугаар байр эзлэхдээ улсынхаа залуучуудын болон насанд хүрэгчдийн амжилтыг шинэчлэн тогтоолоо. Энэ ангилалд нийт 37 тамирчин өрсөлдөж, БНСУ, Японы тамирчид медальт байрт шалгарчээ. Я.Зоригтбаатар өмнө нь 2016 оны арваннэгдүгээр сард Беларуст болсон Дэлхийн цомын тэмцээний үеэр 500 метрийг 37.94 секундэд туулж, улсын залуучуудын рекордыг шинэчлэн тогтоож байсан юм. Я.Зоригтбаатар 18 настай. "Үндэсний шигшээ баг", "Алдар" спорт хорооны тамирчин бөгөөд дасгалжуулагч Д.Энхбаярын удирдлага дор бэлтгэл сургуулилтаа хийдэг юм. Алматагийн "Универсиад 2017" наадамд тэшүүрээр Ж.Должинсүрэн дасгалжуулагчийн удирдлагад М.Мөнх-Од, Я.Зоригтбаатар, Б.Тулга, А.Зул нарын тамирчид оролцож байна. Дэлхийн оюутны спортын "Универсиад" өвлийн наадам энэ сарын 8-ны өдөр өндөрлөнө.

## Н.Төгсцогт гурван тулааны дараа бүсний төлөө өрсөлдөнө

Мэргэжлийн боксын рингэнд долоон үнэмлэхүй ялалт байгуулаад буй олимп, ДАШТ-ий мөнгөн медальт, гавьяат тамирчин Н.Төгсцогтын ээлжит тулаан ирэх сарын 12-нд болох гэж байна. Одоогоор түүнтэй өрсөлдөх тамирчны нэр тодроогүй бөгөөд манай гавьяат үлдэж буй гурван тулааны дараа энэ оны эцэст дэлхийн аваргын бүсний төлөө өрсөлдөх юм. Тэрбээр оны өмнө долоо дахь ялалтаа байгуулсанаар жингийнхээ 1514 тамирчнаас 73 дугаар байрт эрэмбэлэгдсэн билээ.


# ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2017 оны 02 дугаар сарын 03-ны өдөр
**Тендер шалгаруулалтын нэр:** "Хоол тэжээлийн тусламж, дэмжлэг" хүнсний эрхийн бичгээр үйлчилгээ үзүүлэх дэлгүүрүүдийг сонгон шалгаруулах
**Тендер шалгаруулалтын дугаар:** ОР-120/2017

Орхон аймгийн ЗДТГ нь эрх бүхий тендерт оролцогчдыг "Хоол тэжээлийн тусламж, дэмжлэг" хүнсний эрхийн бичгээр үйлчилгээ үзүүлэх хүнсний дэлгүүр сонгон шалгаруулах тухай битүүмжлэл бүхий тендер ирүүлэхийг урьж байна.

Нийт 19 байршил (багц) 19 хүнсний дэлгүүрийг сонгон шалгаруулна.

Гэрээ байгуулах эрхийг багц тус бүрээр олгоно. 1 багцад 1 оролцогчтой гэрээ байгуулна.

Багц тус бүр батлагдсан төсөвт өртгийн 1 хувиар тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийн баримт бичигт техникийн тодорхойлолт, тендерт тавих шаардлага болон багцын мэдээлэлийг хавсаргасан болно.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь 30.000 төгрөгөөр худалдан авч болно.

Тендерийн баримт бичгийн үнийг доорхи дансаар тушаана.

Төрийн сан - 902500

**Дансны дугаар:** 100210051424

Хүлээн авагч: Ор.ОНӨмчийн газар н.с

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерийг 2017 оны 02 дугаар сарын 20-ний өдрийн 10 цаг 00 минут-аас өмнө доорхи хаягаар ирүүлнэ.

Нутгийн удирдлагын ордон 1 давхар 108 тоот

Тендерийн нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2017 оны 02 дугаар сарын 20-ний өдрийн 10 цаг 30 минутанд Аймгийн Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагааны Сургалт мэдээллийн танхимд нээнэ.

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**Орхон аймгийн ЗТДГазар, Нутгийн удирдлагын ордон**
**1 давхар 114 тоот өрөө Утас:70358570**

# ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2017 оны 02 сарын 03 өдөр
**Тендер шалгаруулалтын нэр:** Баянцагаан баг. Дулаан цэвэр усны шугам шинэчилэх, дулаалах /хуучинаар 40 цагаан байр /
**Тендер шалгаруулалтын дугаар:** ОР-04/2017

Орхон аймгийн ЗДТГ эрх бүхий тендерт оролцогчдоос Баянцагаан баг. Дулаан цэвэр усны шугам шинэчилэх, дулаалах /хуучинаар 40 цагаан байр/ ажил гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь 100,000 /нэг зуун мянган/ төгрөгөөр худалдан авч болно. Тендерийн баримт бичгийн үнийг доорхи дансаар тушаана.

Төрийн сан - 902500

**Дансны дугаар:** 100210051424

**Хүлээн авагч:** Ор.ОНӨмчийн газар н.с

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна. Тендерт оролцогч нь дараах шаардлагыг хангасан байна.

**Үүнд:**

- Санал болгож буй үнийн дүнгийн 50 хувьтай тэмцэх хэмжээний түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон зээл авах боломжтой байх
- 2015, 2016 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх
- Дараах тусгай зөвшөөрөлтэй байх: Үүнд: Барилгын ажлын 2.2.4. Дулааны болон усан хангамжийн гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт тусгай зөвшөөрөлтэй байх.

Тендерийн хамт санал болгож буй үнийн дүнгийн 1 хувьтэй тэнцэх хэмжээний тендерийн тендерийн баталгаа ирүүлнэ. Тендерийг 2017 оны 03 сарын 06-ны өдрийн 09 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 03 сарын 06-ний өдрийн 09 цаг 20 минутанд нээнэ.

**Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.**
**Дотоодын давуу эрх тооцно.**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**Орхон аймгийн ЗТДГазар, Нутгийн удирдлагын ордон**
**1 давхар 114 тоот өрөө Утас:70358570**

# СПОРТ

FOOTBALL NEWS



# “ЧЕЛСИ”-ГИЙН БҮДРЭЛТИЙГ НЭХЭГЧИД АШИГЛАЖ ЧАДСАНГҮЙ

Н.БОЛД

Английн премьер лигийн 23 дугаар тойргийн тоглолтууд өнгөрсөн мягмар, лхагва гарагийн шөнө болж өндөрлөлөө. Энэ тойргийн дараах байдлаар хүснэгтийн байрлалд онцын өөрчлөлт орсонгүй. Хоёр, гуравдугаар байрт бичигдэж байгаа багийн байрлал өөрчлөгдсөнийг эс тооцвол. Хүснэгтийг тэргүүлэгч “Челси” клуб энэ удаад “Ливерпүүл”-ийн талбайд зочилж тоглосон. Энэ тоглолтоос “Цэнхэрүүд” оноо алдах магадлалтай байсан учраас нэхэж буй багуудад боломж болох байлаа. Тэр ч ёсоор болж “Ливерпүүл” талбайдаа “Челси”-тэй 1:1-ээр тэнцсэн. Тоглолтын 24 дэх минутад Давил Луйз чөлөөт цохилтоос гоолдож, тооны харьцааг нээсэн. Тэрбээр хаалгачийн хайнга байдлыг ашиглан, овжин гоол оруулснаар багтаа тэргүүлэл авчирсан юм. Харин 57 дахь минутад Вейналдум тэнцүүлж дөнгөсөн. Цагийн төгсгөл рүү Коста торгуулийн цохилт цохисон ч “Ливерпүүл”-ийн хаалгач хааснаар багаа ялагдлаас аварсан юм. Ийнхүү “Челси” нэг оноо зулгааж, 56 оноотой боллоо. Харин “Ливерпүүл” 46 оноотой болж, дөрөвдүгээр байрт бичигдэж байна. “Челси”-г хоёр оноо алдаж байхад “Арсенал” клуб талбайдаа “Уотфорд”-ыг хүлээж авч, 1:2-оор хожигдлоо. Ингэснээр 47 оноотой хэвээр үлдэж, гуравдугаар байр руу ухарлаа.

Мөн тэргүүлэгч рүү ойртох боломжоо алдаж, бүр есөн оноогоор хоцорч эхэллээ. Тоглолтын 10 дахь минутад Кабуль тооны харьцааг нээж, 13 дахь минутад Дини нэгийг нэмжээ. Тэгвэл “Арсенал”-аас 58 дахь минутад Ивоби нэг гоол оруулсан байна. “Тоттенхэм” клуб ч гэсэн тэргүүлэгчдийн бүдрэлтийг олигтой ашиглаж чадсангүй. Уг нь Лондоны нөгөө багууд нь тэнцэж, хожигдож байх зуур тэд хожих л ёстой байлаа.

Харамсалтай нь, “Сандерланд”-ын талбайд хуурай тэнцсэнээр ердөө ганцхан оноо авлаа. Гэхдээ 47 оноотой болж, гоолын зөрүүгээр“Ихбуучид”-ындээр бичигдэж, хоёрдугаар байр руу орж ирж байгаа юм. Энэ тойрогт ганц гайгүй тоглож хожсон баг нь “Манчестер Сити” байлаа. Ерөөсөө топ зургаан багаас ганцхан “Сити” л хожсон. “Хотынхон” энэ тойрогт “Вест Хэм”-ийн талбайд зочилж, 0:4-өөр буулгаж авлаа. Ингэснээр 46 оноотой болж, “Ливерпүүл”-тэй зэрэгцэж ирлээ. Гэхдээ гоолын зөрүүгээр тавдугаар байрт бичигдэж байгаа юм.

Тоглолтын 17 дахь минутад Кевин Де Брюйне тооны харьцааг нээсэн бол 21 дэх минутад Сильва нэгийг нэмжээ. Улмаар 39 дэх минутад “Сити”-гийн шинэ тоглогч Габриэл Жезус нэгийг нэмсэн бол Яя Туре 67 дахь минутад торгуулийн цохилтоос гүйцээсэн байна. Мөн энэ шатанд “Манчестер Юнайтед” клуб талбайдаа “Халл”-ыг хүлээж авч, хуурай тэнцлээ. Ингэснээр 42 оноотой болж, зургадугаар байрт бичигдэж байна. Унах шатны өрсөлдөөн ч ойрын үед ширүүхэн болж байгаа. “Суонси” энэ тойрогт талбайдаа “Саутгэмптон”-ыг 2:1-ээр буулгаж авснаар 21 оноотой болж, хасагдах бүсээс сугарлаа. Сүүлийн хоёр тоглолт дараалан хожсон нь тэднийг хасагдах бүсээс гаргаж байгаа юм. 23 тойргийн дараагаар “Крситал Палас”, “Халл Сити”, “Сандерланд” багууд хасагдах бүсэд бичигдэж байна.



## Гризманн “Юнайтед”-тай жилийн 17.7 сая еврогийн цалинтай гэрээ хийхээр тохиролцжээ

Английн алдарт “Манчестер Юнайед” клуб Испанийн “Атлетико Мадрид”-ын довтлогч Антуан Гризманныг ирэх зуны солилцоо наймаанц цонхоор авахаар тохиролцоонд хүрсэн байна. Элүгээ 25 настай Франц эр хувийн гэрээний нөхцлөө ч бас тохиролцсон аж. Тэрбээр “Манчестер Юнайтед” клубт ирснээр жилийн 17.7 сая еврогийн цалин авах юм байна. Энэ нь шигшээ багийн анд Пол Погбатай ижил хэмжээний цалин гэсэн үг ажээ. “Атлетико”-гийн хувьд Гризманнтай 2021 он хүртэл гэрээтэй. Хэрвээ түүнээс өмнө өөр баг түүнийг авна гэвэл 100 сая евро төлөх ёстой юм. Энэ мөнгийг “Манчестер Юнайтед” өгөх ажээ.

## Крауч премьер лигийн 100 дахь гоолоо орууллаа

Английн премьер лигийн 23 дугаар тойргийн хүрээнд “Сток Сити” клуб “Эвертон”-тай тулж, 1:1-ээр тэнцсэн билээ. Энэ тоглолтод “Сток Сити”-гийн довтлогч Петр Крауч нэг гоол оруулсан. Ингэснээр тэрбээр Английн премьер лигийн 100 дахь гоолоо оруулж байгаа юм. Тэрбээр 36 нас хоёр өдөртэйдээ ийнхүү лигийн 100 дахь гоолоо оруулж чадлаа. Тэрбээр энэ улиралд премьер лигийн 15 тоглолтод оролцож, дөрвөн гоол оруулж, хоёр гоолын дамжуулалт өгчихөөд байгаа юм. Крауч цагтаа “Астон Вилла”, “Саутгэмптон”, “Ливерпүүл”, “Портсмут”, “Тоттенхэм” клубүүдэд тоглож явсан билээ. “Ливерпүүл”-д гурван улирал тоглохдоо 22 гоол оруулж байсан бол “Тоттенхэм”-д хоёр жил тоглож, 12 гоол хийжээ. Харин 2011 оноос хойш “Сток Сити”-гийн төлөө зургаа дахь улиралдаа тоглож байгаа бөгөөд энэ хугацаанд 36 гоол оруулчихаад байна.

## “Рома” клуб Италийн цомын хагас шигшээд шалгарлаа

Италийн цомын тэмцээний хагас шигшээ шатны сүүлчийн тоглолт өнгөрсөн лхагва гарагийн шөнө боллоо. Энэ шатанд “Рома” клуб талбайдаа “Чезена”-г хүлээж авч, 2:1-ээр буулгаж авлаа. Ингэснээр хагас шигшээ шат руу орж байгаа юм. Тоглолтын 68 дахь минутад Жеко тооны харьцааг нээсэн бол 73 дахь минутад Гарритано тэнцүүлжээ. Гэвч 90+5 дахь минутад Тотти торгуулийн цохилтоо гоолдож, багтаа ялалт авчирчээ. Ингэснээр “Ювентус”, “Наполи”, “Лацио”, “Рома” гэсэн дөрвөн баг хагас шигшээд шалгарч байгаа юм.

## Хүчингүйд тооцов

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1 дүгээр багийн 122 байрны 4 тоот V-1902001023 улсын бүртгэлийн дугаар бүхий бүхий ЕЙ46031518 регистрийн дугаартай Дэндэв овогтой Улаанхүү, ЕЙ51120501 регистрийн дугаартай Чанцалдулам овогтой Дашдулам, ЕЙ02321201 регистрийн дугаартай Мөнх-Эрдэнэ овогтой Анар нарын эзэмшлийн байрны гэрчилгээ гээгдүүлсэн тул хүчингүйд тооцов.

УГАНЭ ХХК-ийн харьяа Анар хүнсний дэлгүүрийн 1102 тоот газрын гэрчилгээтэй хүнсний дэлгүүрийн тамхи зарах зөвшөөрөл гээсэн тул хүчингүйд тооцов.


## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2017 оны 02 сарын 03 өдөр
**Тендер шалгаруулалтын нэр:** Гэр хорооллын ИШС-ны өргөтгөл /Уртын гол, Рашаант, Наран, Баянбулаг, Булаг баг /
**Тендер шалгаруулалтын дугаар:** ОР-05/2017

Орхон аймгийн ЗДТГ эрх бүхий тендерт оролцогчдоос Гэр хорооллын ИШС-ны өргөтгөл /Уртын гол, Рашаант, Наран, Баянбулаг, Булаг баг /-ийн ажил гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь 100,000 /нэг зуун мянган/ төгрөгөөр худалдан авч болно.

Тендерийн баримт бичгийн үнийг доорхи дансаар тушаана.

Төрийн сан - 902500
**Дансны дугаар:** 100210051424
**Хүлээн авагч:** Ор.ОНӨмчийн газар н.с

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь дараах шаардлагыг хангасан байна.

**Үүнд:**

- Санал болгож буй үнийн дүнгийн 50 хувьтай тэмцэх хэмжээний түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон зээл авах боломжтой байх
- 2015, 2016 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх
- Дараах тусгай зөвшөөрөлтэй байх: Үүнд: Барилгын ажлын 2.2.4. Дулааны болон усан хангамжийн гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт тусгай зөвшөөрөлтэй байх.

Тендерийн хамт санал болгож буй үнийн дүнгийн 1 хувьтэй тэнцэх хэмжээний тендерийн тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 03 сарын 06-ны өдрийн 09 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 03 сарын 06-ний өдрийн 09 цаг 40 минутанд нээнэ.

**Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.**
**Дотоодын давуу эрх тооцно.**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**Орхон аймгийн ЗТДГазар, Нутгийн удирдлагын ордон 1 давхар 114 тоот өрөө Утас:70358570**

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2017 оны 02 сарын 03 өдөр
**Тендер шалгаруулалтын нэр:** Гэр хорооллын эцсийн 3-р сургуулийн засвар
**Тендер шалгаруулалтын дугаар:** ОР-31/2017

Орхон аймгийн ЗДТГ эрх бүхий тендерт оролцогчдоос Гэр хорооллын эцсийн 3- р сургуулийн засвар–ын ажлыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь 100,000 /нэг зуун мянган/ төгрөгөөр худалдан авч болно.

Тендерийн баримт бичгийн үнийг доорхи дансаар тушаана.

Төрийн сан - 902500
**Дансны дугаар:** 100210051424
**Хүлээн авагч:** Ор.ОНӨмчийн газар н.с

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь дараах шаардлагыг хангасан байна.

**Үүнд:**

- Санал болгож буй үнийн дүнгийн 50 хувьтай тэмцэх хэмжээний түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон зээл авах боломжтой байх
- 2015, 2016 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх
- Дараах тусгай зөвшөөрөлтэй байх: Үүнд: Барилгын ажлын 2.1.1. Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт, 2.2.1. Барилгын дотор халаалт, салхивч, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт, тусгай зөвшөөрөлтэй байх.

Тендерийн хамт санал болгож буй үнийн дүнгийн 1 хувьтэй тэнцэх хэмжээний тендерийн тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 03 сарын 06-ны өдрийн 09 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 03 сарын 06-ний өдрийн 10 цаг 00 минутанд нээнэ.

**Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.**
**Дотоодын давуу эрх тооцно.**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**Орхон аймгийн ЗТДГазар, Нутгийн удирдлагын ордон 1 давхар 114 тоот өрөө Утас:70358570**

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Тендер шалгаруулалтын нэр:** Баянцагаан багийн 2.7 км авто замын 1-р хэсгийн үлдэгдэл ПК
**Тендер шалгаруулалтын дугаар:** ОР-68/2017
**Огноо:** 2017-02-03

Орхон аймгийн засаг даргын тамгын газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос Баянцагаан багийн 2.7 км авто замын 1-р хэсгийн үлдэгдэл ПК ажил–ыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь 100,000 /нэг зуун мянган/ төгрөгөөр худалдан авч болно.

Тендерийн баримт бичгийн үнийг доорхи дансаар тушаана.

Төрийн сан 9025
**Дансны дугаар:** 100210051424
**Хүлээн авагч:** ОР.ОНӨГ нэмэлт санхүүжилт

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

**Үүнд:**

Санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй хэмжээний түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон зээл авах боломжтой байх

2015, 2016 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх

Санал болгож буй үнийн дүнгээс багагүй хэмжээний ижил төстэй ажлыг сүүлийн 2 жилд гүйцэтгэсэн байх

Дараах тусгай зөвшөөрөлтэй байх: 3.7.1.1.4 Хатуу хучилттай зам барих

Тендерийн хамт санал болгож буй үнийн дүнгийн [1%] төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 03 дугаар сарын 06-ний өдрийн 09 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 03 дугаар сарын 06-ний өдрийн 09 цаг 30 минутанд нээнэ.

**Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.**
**Дотоодын давуу эрх тооцно.**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**Орхон аймгийн ЗДТГ, Нутгийн удирдлагын ордон 1 давхар 113 тоот өрөө Утас:70358570**

# СПОРТ

АМЖИЛТЫН ЭЗЭН

# Б.СУМЪЯА: Амжилтын төлөө энэ спортоор хичээллэж байгаа учир гаднаас санал ирвэл би явна



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

**Төгсгөл.**
**Түрүүч нь V нүүрт**

**-Улсын аварга шалгаруулах тэмцээн болж өндөрлөсөн. Энэ удаагийн улсын аваргад хэдэн метрийн зайд уралдаж, ямар амжилт үзүүлэв?**

-Бага олон төрөлтийн улсын аварга шалгаруулах тэмцээн 500, 1000, 1500, 3000 метрийн зайд болоод нийлбэр дүнгээр аваргуудаа тодруулдаг. Бүх зайд уралддаг. Би 500, 1500, 3000 метрийн зайд хоёрдугаар байрт орж, 1000 метрийн зайд түрүүлсэн. Мөн нийлбэр дүнгээр түрүүлж, улсын аварга болсон.

**-Монголд өрсөлдөгч хэр байна. Дөрвөн зайн гуравт нь хоёрдугаар байрт орсон гэхээр нэлээд өрсөлдөөнтэй улсын аварга болж дээ?**

-Цөөхөн хүчтэй өрсөлдөгч л байгаа. Түүнээс биш хүчтэй өрсөлдөөн үзүүлэхээр олон тамирчин байхгүй. Үндэсний шигшээ багийн гурван эмэгтэй тамирчин хоорондоо өрсөлддөг. Тэр гурван тамирчны хооронд гол өрсөлдөөн болсон. Тухайлбал, 500 метрийн зайд гэхэд 20 тамирчин уралдсан. Оролцогчдын хувьд бол цөөдөхгүй. Гэхдээ шигшээ багийн гурван тамирчин хоорондоо хүчтэй өрсөлдөөн үзүүлж, долийн зөрүүтэй барианд орж, эхний байруудад шалгарч байгаа юм. Бусад нь бол биднээс секундээр хоцорч барианд орсон. Хөдөө, орон нутгаас цөөнгүй тамирчин ирж оролцсон. Мөн дэлхийн оюутны универсиад наадам болж байгаа болохоор оюутан тамирчид их оролцсон шүү.

**-Улсын аваргын өмнө бэлтгэлээ Монголдоо л базаасан уу. Ямархуу нөхцөлд бэлтгэл хийж байна вэ?**

-Хандгайтын мөсөн гулгуурын талбайд бэлтгэлээ хийсэн. Шигшээ багийн тамирчдыг “Олимп” цогцолборт байрлуулаад, бэлтгэл хийлгэсэн. Шигшээ багийнхан тэндээ бөөгнөрөөд л бэлтгэлээ хийсэн дээ. Нөхцөл бол тааруу. Үндэсний шигшээ багаас зургаан тамирчин, хоёр дасгалжуулагч, Тэшүүрийн холбооноос гурван тамирчны зардлыг гаргаж, тэнд 10 гаруйхан хүн байрлаж бэлтгэл хийсэн. Бид яах вэ, “Олимп” цогцолборт байрласан болохоор гайгүй. Бусад тамирчид өглөө Улаанбаатар хотоос автобусаар ирээд, орой буцдаг. Хувцас солих байр нь гэхэд зүгээр нэг чингэлэг. Мөс нь шаардлага хангахгүй. Зарим газраа хагарчихсан, үелчихсэн байх жишээтэй. Ерөнхийдөө л хэцүүхэн нөхцөлд тэшүүрийн тамирчид бэлтгэлээ хийж, улсын аваргаа зохион байгуулсан гэхэд болно.

**-Энэ удаагийн улсын аваргаар үзүүлсэн цаг ямар байв. Олон улсын тэмцээн уралдааны амжилттай харьцуулбал?**

-Ерөнхийдөө гайгүй уралдсан. Гэхдээ битүү мөсөн гулгуурын талбайд уралдсанаас эрс өөр л дөө. Мөсний хатуулаг чанар, цаг агаарын байдлаас шалтгаалаад задгай талбайн амжилт муу байдаг.

**-Шигшээ багийнхан оны өмнө Хятад руу явж бэлтгэл хийсэн дээ. Тийм болохоор бусдаасаа хамаагүй илүү байсан байх?**

-Шигшээ багийн тамирчид өнгөрсөн оны аравдугаар сард 21 хоногийн бэлтгэл хийгээд ирсэн. Я.Зоригтбаатар бид хоёр арваннэгдүгээр сард Беларусь руу явж, Залуучуудын дэлхийн цомд оролцсон. Бусад тамирчид Монголдоо бэлтгэлээ хийж байгаа шүү дээ. Шигшээ багийн тухайд гурван тамирчинтай. Нэг нь бүр өнгөрсөн оны наймдугаар сараас хойш Хятадад мөсөн дээр гарч байгаад арваннэгдүгээр сард ирсэн. Биднийг бодвол мөсний бэлтгэл илүү хийсэн учраас энэ удаагийн улсын аваргад сайн оролцсон. 500 метрийн зайд түрүүлсэн. Ер нь бол бид зуны хуурай бэлтгэлээр л мөсний бэлтгэлээ нөхдөг. Бусад орны тамирчид наймдугаар сараас хойш мөсөн дээр гараад, бэлтгэлээ хийгээд, хоёр, гуравдугаар сар хүртэл гулгачихдаг. Гэтэл бид тэгж чадахгүй байна. Энэ жил гэхэд өнгөрсөн арванхоёрдугаар сарын сүүлчээр л мөстэй золгосон. Тэр нь чанарын болоод стандарт шаардлага хангахгүй. 400-гийнх биш 200 метрийн талбайд гулгана. Сагсаар бол нэг талдаа л тоглоод байгаагаас ялгаагүй гэсэн үг л дээ.

**-Одоо удахгүй Японд Азийн тоглолт болно. Тийшээ явах гээд л бэлтгээд байна уу?**

-Бэлтгэлээ Хандгайтдаа л хийнэ. Өөр бэлтгэл хийх газар Монголд байхгүй шүү дээ. Гадагшаа цугларалтад гарах арай болоогүй байх. Манай зарим тамирчид Казахстан руу универсиадад явчихсан байгаа.

**-Азийн төвшинд түрүүлж буй тамирчдын үзүүлж байгаа цаг гэж бий. Тэгвэл чиний Монголд бэлтгэл хийгээд үзүүлж байгаа цаг тэдний үзүүлэлт рүү дөхөж очиж байна уу?**

-Дөхөж очно оо, хоёр, гурван секундын зөрүүтэй л байгаа. Гэхдээ энэ бол нэлээд хөдөлмөрлөж байж нөхөх цаг л даа. Тэмцээний өмнө бид Японд эрт очоод, мөсөн дээр гараад, орчин нөхцөлдөө дасах цаг байхгүй юм билээ. Энэ сарын 18-нд Японд очино гэсэн. Тэмцээн 20-нд эхлэх байсан байх аа. Тэгэхээр бэлтгэл хийх цаг байхгүй гэсэн үг. Гэхдээ яах вэ, огт өөр биш, адилхан л мөс шүү дээ. Цагийн зөрүү ч гайгүй. Монголоос тэшүүрийн төрөлд зургаан тамирчин оролцоно. Би 500, 1000, 1500 метрийн зайд уралдах байх.

**-Аль зайд нь илүү амжилт үзүүлэх боломжтой гэж бодож байна?**

-Ерөнхийдөө гурвууланд нь сайн уралдах боломжтой. Хувийнхаа амжилтыг ахиулах зорилготой байгаа. Хувийнхаа рекорд амжилтыг эвдэнэ гэж төлөвлөж байна.

**-Фэйсбүүк хуудастдаа заримдаа нэлээд бухимдангуй пост оруулж харагддаг. Тэшүүрийн холбооны үйл ажиллагаанд сэтгэл дундуур байгаагаа илэрхийлээд байх шиг. Ер нь бухимдахаар зүйл их гарч байна уу?**

-Холбооны үйл ажиллагаа сүүлийн жилүүдэд эрс муудсан. Тийм болохоор би нэлээд бухимдалтай байгаа. Тамирчид ч гэсэн их хохирч байна шүү дээ. Тамирчдыг бэлтгэл сургуулилт хийлгэх, дэмжих тал дээр ажиллахгүй байгаа. Миний харж байгаагаар хувийн ашиг сонирхол давамгайлаад байна уу гэж боддог. Зарим тамирчдыг илүү дэмжих, нөгөөг нь шахах байдал хүртэл ажиглагддаг. Тухайлбал, саяоюутны универсиад наадамд гэхэд намайг явуулаагүй. Д.Энхбаяр багш бид хоёрын нэрийг хасчихсан байсан. Яагаад тэгсэн юм, бүү мэд. Гэх мэт асуудал байгаа. Универсиад наадамд тэшүүрчдээс гурван эрэгтэй, нэг эмэгтэй тамирчин, нэг дасгалжуулагчийн хамт явсан. Эмэгтэй тамирчин Хятадад олон сар гулгасан Зул гэдэг охин л доо. Уг нь бид хоёрын дунд сорилго хийгээд ч юм уу, сонгон шалгаруулах маягаар явуулах болов уу гэж бодож байсан юм. Гэтэл яаж ч шийдсэн, жаахан хаалттай маягаар л сонгоод явуулчихсан.

**-Цаашдын зорилго бол Олимп, дэлхийн хэмжээнд амжилт үзүүлэх л байж таарна. Тэгэхийн тулд чухам юу дутаад байна вэ?**

-Мөс л дутагдаж байна. Дэмжлэг туслалцаа гэж байхгүй. Шигшээ багийн хэдхэн тамирчин арай дээр. Бусад тамирчдын хувьд ямар ч орчин нөхцөл алга. Шигшээ багийнхан ч гэсэн хангалттай хэмжээнд бэлтгэл хийж чадахгүй байна. Яах вэ, бусад тамирчдаа бодвол арай дээр л гэж байгаа юм. Битүү дээвэртэй ордонтой болчих юм бол амжилт хамаагүй өснө. Хувь тамирчдын ур чадварын хувьд дэлхийн шилдгүүдээс нэг их дутаад, тасраад үлдчихсэн гэж би бодохгүй байна. Гадаадын тамирчид мөсний гулгалт, бэлтгэл хамаагүй илүү. Бид тэдэнтэй адилхан наймдугаар сараас эхлээд мөсөн дээр гараад, дөрөвдүгээр сар хүртэл тасралтгүй бэлтгэл хийчихвэл амжилт өснө. Тэдэнтэй өрсөлдөхүйц хэмжээнд очно. Одоо бол бид зуны бэлтгэлээрээ л бүх зүйлээ нөхдөг. Зун бэлтгэлээ маш сайн хийж байгаа болохоор гадны, өөрийнхөө насны залуу тамирчдаас хол хаягдчихалгүй өрсөлдөөд байгаа юм. Тасархай хол хоцрохгүй. Гэхдээ насанд хүрэгчдийн дэлхийн цомд өрсөлдөж байгаа тамирчдын хаана нь ч хүрэхгүй л дээ. Тэд чинь маш өндөр хангамжийн дор бэлтгэл хийж байгаа шүү дээ.

**-Тэр тамирчидтай өрсөлдөж, ялж байж л Олимпийн наадамд оролцоно биз дээ?**

-Харин тийм. Тэгэхээр адилхан л хангамжтай байж гэмээнэ тэдэнтэй өрсөлдөнө, ижил хэмжээнд уралдана шүү дээ. Тухайлбал, үзүүлж байгаа цагийн амжилтаа харьцуулаад үзье л дээ. Дэлхийн цомд медаль хүртэж байгаа эмэгтэй тамирчид 500 метрийн зайд гэхэд 38 секунд гүйж байгаа. 40 секундын амжилт үзүүлж байж насанд хүрэгчдийн дэлхийн цомд оролцох эрхтэй болно. 41-ээс дотогшоо гүйж байж дэлхийн цомд орж чадна гэсэн үг. Тэр тэмцээнд түрүүлж байгаа хүмүүс 37, 38 л гүйж байна. Мөснөөсөө бас шалтгаална. Монголын 500 метрийн рекорд амжилт 41.09. Дэлхийн цомын эрх авахад нэлээд дөхөж байгаа. Гэхдээ л бас болоогүй байна. 40 секунд гүйлээ гэж бодъё л доо, тэглээ гээд медальт байрт шалгарах боломж байхгүй. Медаль авч байгаа хүмүүс 38 секундын дотор долиор өрсөлдөж байна шүү дээ. Манай Монголын 500 метрийн рекорд 41.09 гэсэн дээ. Энэ амжилтыг сая Универсиад наадамд явсан Зул эзэмшдэг. Гэхдээ Канад, АНУ, Хятадад байдаг хурд сайн гардаг мөсөн дээр тогтоосон цаг. Монголд 500 метрт 44 секунд л гүйж байгаа шүү дээ. Дэлхийн цомд түрүүлж байгаа тамирчдаас даруй зургаан секундээр хоцорч байна. Гэхдээ бид тэдэнтэй адилхан төвшинд бэлтгэл хийгээд, ижил хангамжтай байвал илүү гарна уу л гэхээс дутахгүй шүү.

**-Тамирчин хүн болгоны хүсэл бол дэлхийн шилдгүүдтэй өрсөлдөж, амжилт гаргах байдаг. Гэтэл өнөөдөр тэшүүр болоод өвлийн спортын тамирчдыг дэмжиж байгаа юм алга. Дэлхийн шилдгүүдийн шилдгүүд долиор өрсөлдөж байхад бид секунд яриад сууж байна. Ийм нөхцөлд шантрах үе гарах уу?**

-Мэдээж шантрах үе гарна, янз бүрийн л юм бодогдоно. Битүү дээвэртэй ордон байхгүй болохоор гадаа бэлтгэл хийхэд маш их даардаг. Сая улсын аваргын өмнөхөн би хацраа, хамрынхаа үзүүрийг хөлдөөсөн. Хөл хөлдөх бол энүүхэнд. Хагарсан мөсний завсраар тэшүүр ороод, унах, бага сага гэмтэх тохиолдол ч гарна. Гэхдээ юуны төлөө энэ спортоор хичээллэж, зорьж байгаа билээ. Хэзээ нэгэн цагт тэдэнтэй уралдаад ялах цаг ирнэ. Хамгийн гол нь тэр болтол бэлтгэлээ сайн хийж байвал болно гэж боддог. Удахгүй дэлхийн хэмжээнд хүрдэггүй юм гэхэд нэг их дутахааргүй хангамжтай болно гэж бодож, мөрөөдддөг. Би одоо дөнгөж 18-хан настай байна. Хүмүүс 25, 26 нас хүрээд илүү амжилт үзүүлж байгаа харагддаг. Надад амжилт гаргах он жил хангалттай байна.

**-Манай улсын шинэ, шилдэг залуу тамирчдыг гадныхан авах гээд, янз бүрийн санал тавиад байгаа шүү дээ. Чамд санал ирж байна уу?**

-Ганц хоёр санал ирсэн сураг байсан. Гэтэл “Өөр тамирчин байгаа” гээд болиулсан гэсэн. Тухайлбал, Норвегиос тийм санал ирсэн юм шиг байна билээ. Тэшүүрийн холбоогоор дамжиж санал ирж байгаа болохоор бид нарийн мэдээллийг нь сонсоогүй. Ямар ч байсан манайд өөр шилдэг тамирчин байгаа, түүнийг авах уу гэж цаад талдаа санал болгосон юм билээ. Гэтэл цаад тал нь дахиж санал тавилгүй орхисон гэсэн. Нэг иймэрхүү зүйл холбоо хавиар болоод байгаа юм. Ерөнхийдөө нэг тамирчин руу илүү хандсан, дэмжсэн байдалтай л байгаа юм уу даа, янз нь.

**-Хэрвээ дэлхийн шилдэг тамирчидтай адилхан хэмжээний цалин, хангамж өгье гэсэн санал ирвэл явах уу?**

-Хэрвээ байнга мөсөн дээр гарч бэлтгэл хийгээд, дэлхийн том тамирчидтай адилхан хангамж эдлэхээр боломжийн санал гаднаас ирвэл явна. Амжилт гаргахын төлөө л энэ спортоор хичээллэж байгаа юм чинь Монголд юу хүлээж байх юм. Явсан нь дээр шүү дээ. Манайд одоохондоо ямар ч хангамж алга. Сайхан болно гэж найдаад, хий мөрөөдөөд л байж байна. Гэхдээ тийм болтол хэзээ ч билээ, тийм биз дээ. Тийм болохоор би сайхан санал ирвэл явна аа.

**-Хамгийн ойрын зорилгоосоо хуваалцвал?**

-Ирэх гуравдугаар сард Канадын Калгарид болох тэмцээнд очиж, хурд сайн гардаг мөсөн дээр уралдана. Тэнд томчуудын дэлхийн цомын эрх хийх зорилготой байна. Хэрвээ насанд хүрэгчдийн дэлхийн цомд оролцож чадвал цаашлаад Олимпийн наадамд оролцохын төлөө хөдөлмөрлөнө дөө.

...Ганц хоёр санал ирсэн сураг байсан. Гэтэл “Өөр тамирчин байгаа” гээд болиулсан гэсэн. Тухайлбал, Норвегиос тийм санал ирсэн юм шиг байна билээ. Тэшүүрийн холбоогоор дамжиж санал ирж байгаа болохоор бид нарийн мэдээллийг нь сонсоогүй. Ямар ч байсан манайд өөр шилдэг тамирчин байгаа, түүнийг авах уу гэж цаад талдаа санал болгосон юм билээ...


## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Тендер шалгаруулалтын нэр:** МОН-2301 төслөөр баригдсан цэвэр усны шугмын 2-р эх үүсвэр (1-р хэсэг)
**Тендер шалгаруулалтын дугаар:** OP-02/2017
**Огноо:** 2017-02-03

Орхон аймгийн засаг даргын тамгын газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос МОН-2301 төслөөр баригдсан цэвэр усны шугмын 2-р эх үүсвэр (1-р хэсэг) ажил–ыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь 200,000 /хоёр зуун мянган/ төгрөгөөр худалдан авч болно.

Тендерийн баримт бичгийн үнийг доорхи дансаар тушаана.

Төрийн сан 9025

**Дансны дугаар:** 100210051424

**Хүлээн авагч:** ОР.ОНӨГ нэмэлт санхүүжилт

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

**Үүнд:**

Санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй хэмжээний түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон зээл авах боломжтой байх

2015, 2016 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх

Дараах тусгай зөвшөөрөлтэй байх: Үүнд: Тусгай зөвшөөрөл: 2.2.4-Дулааны болон усан хангамжийн гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт

Тендерийн хамт санал болгож буй үнийн дүнгийн [1%] төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 03 дугаар сарын 06-ний өдрийн 09 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 03 дугаар сарын 06-ний өдрийн 09 цаг 30 минутанд нээнэ.

**Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.**
**Дотоодын давуу эрх тооцно.**
*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**Орхон аймгийн ЗДТГ, Нутгийн удирдлагын ордон**
**1 давхар 113 тоот өрөө Утас:70358570**

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Тендер шалгаруулалтын нэр:** Цагаанчулуут багт баригдах УДДТөв №6
**Тендер шалгаруулалтын дугаар:** OP-03/2017
**Огноо:**2017-02-03

Орхон аймгийн засаг даргын тамгын газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос Цагаанчулуут багт баригдах УДДТөв №6 ажил–ыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь 100,000 /нэг зуун мянган/ төгрөгөөр худалдан авч болно.

Тендерийн баримт бичгийн үнийг доорхи дансаар тушаана.

Төрийн сан 9025

**Дансны дугаар:** 100210051424

**Хүлээн авагч:** ОР.ОНӨГ нэмэлт санхүүжилт

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

**Үүнд:**

Санал болгож буй үнийн дүнгийн 50 хувьтай тэмцэх хэмжээний түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон зээл авах боломжтой байх

2015, 2016 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх

Дараах тусгай зөвшөөрөлтэй байх: Үүнд: Тусгай зөвшөөрөл: БХБЯ-ний 2.1.1, 2.1.2 03.5.1-дараалттай шугам хоолой ЦТП-ны засвар, угсралт, түүний туршилт, тохируулга дагалдах ажил үйлчилгээ

Эрчим хүчний яамны 03.2.1, 03,2.2, 03.2.3, 03.2.4, 03.2.5 аль нэг нь байх

Тендерийн хамт санал болгож буй үнийн дүнгийн [1%] төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 03 дугаар сарын 06-ний өдрийн 09 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 03 дугаар сарын 06-ний өдрийн 09 цаг 30 минутанд нээнэ.

**Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.**
**Дотоодын давуу эрх тооцно.**
*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**Орхон аймгийн ЗДТГ, Нутгийн удирдлагын ордон**
**1 давхар 113 тоот өрөө Утас:70358570**

NO STRESS

ДУУЛГАХ СОНИН

Н.БАТЗАЯА




# “Царцаа намжил” жүжиг хүүхдүүдэд монгол соёлыг түгээнэ

“Царцаа намжил” хэмээх үлгэрийг сонсож өсөөгүй монгол хүн гэж байхгүй. Монгол ардын аман зохиол, үлгэрийн өгүүлэмж үйл явдлаар дамжуулан хүүхэд багачуудад эрдэм боловсролын чухлыг таниулж өв соёл, зан заншлаа эрхэмлэн дээдлэх хүсэл эрмэлзэлд хөтлөн төлөвшүүлэх зорилгоор Улсын драмын эрдмийн театрын уран бүтээлч хамт олон Боловсрол, соёл, шинжлэх, спортын яамны “Хүүхдэд зориулсан уран бүтээлийн” төслийн уралдаанд шалгарсан Я.Баяраа, Б.Хишигзаяа нарын зохиол “Царцаа Намжил” хүүхдийн жүжгийг тайзны бүтээл болгож буй юм. Тэгвэл “Царцаа намжил” жүжиг УДЭТ-ын тайзнаа энэ сарын 5-нд амилахаар болжээ. Тус жүжгийн хэвлэлийн бага хурал өчигдөр УДЭТ-т боллоо. Хэвлэлийн хуралд тус жүжгийн найруулагч СТА Б.Хишигзаяа, зохиолч Я.Баяраа, зураач Л.Цэрэндулам, хөгжмийн зохиолч СТА Б.Цацрал, АЖ П.Цэрэндагва, МУГЖ Ж.Оюундарь, СТА С.Болд-Эрдэнэ, СТА Ц.Цэрэнболд, залуу жүжигчин Б.Золжаргал, О.Итгэл, Р.Адъяабаатар нар оролцлоо. Хэвлэлийн хурлын үеэр найруулагч Б.Хишигзаяа “Би бол эх хүн, эмэгтэй хүн. Мэдээж уран бүтээл болон иргэн хүнийхээ хувьд эмзэглэж явдаг зүйлүүд байдаг. Энэ утгаараа хүүхдийн жүжгийг онцолдог. Өнөөгийн нийгэмд хүүхэд гэдэг хамгийн том харах ёстой, анхаарах ёстой орон зай. Хүн болох багаасаа, хүлэг болох унаганаасаа гэж ярьдаг. Тиймээс бид хүүхдэд соёл, жүжгээр дамжуулан маш том хүмүүжил олгодог чухал ажил хийж байгаа гэж боддог. Миний сонгож авсан “Царцаа намжил” жүжиг маань монгол жүжиг. Дэлхийн маш олон сонгодог жүжиг байдаг. Яагаад заавал монгол жүжиг сонгосон юм бэ гэж зарим нэг хүн асууж магадгүй. Бид бүхнийг дэлхийн бүх улсаас ялгах гол онцлог нь үндэсний хэл, соёл, уламжлал, философи гэж ойлгож явдаг. Эдгээрийг хүүхдүүдэд мэдүүлэх нь хамгийн чухал байна. Хүүхдүүд үлгэр мэдэхгүй байна. Эх хэлээрээ ярихаа больсон. Хоорондоо англи, хятад, солонгосоор ярилцаж байна. Өмсөж байгаа хувцас, алхаа гишгээ гээд бүх зүйл нь өөрчлөгдөж байна. Бид одоо монгол хүнээ хайж эхэлж байна. Энэ бол миний хувьд хамгийн том эмзэглэл байсан учраас монгол жүжгийг сонгосон” гэв.

Уг жүжигт энэ хорвоо дээр нэг л ертөнц оршдоггүй билээ. Эгэл жирийн хүмүүс бидний амьдардаг энэ ертөнцийг “Замбуулин хорвоо” хэмээнэ. Харин эгэл жирийн хүмүүс бид, амьтны амь тасалдаггүй, өглөгч энэрэнгүй зантай, үнэнч шударга сэтгэлтэй, шуналгүй, ховч, хуурмаг зангүй бол арван цагаан буянтан гэгдэж, авралт бурхны оронд амьдрах эрхтэй болдог гэдэг. Эрт урьдын цагт Эзэн Чингис ч төрөхөөс өмнө Намжил нэрт нэгэн хүү бурхны оронд очиж, эрдэм сурахаар явсан агаад түүнд тохиолдсон элдэв сонин хэрэг явдлын талаар өгүүлэх юм. Харин зохиолч Я.Баяраа “Б.Хишигзаяа багш оны өмнөхөн надад өөрийнхөө санааг хэлсэн. Энэ жүжгийн гол жолоо нь Б.Хишигзаяа багшийн хэлсэн санаагаар зангилагдаад миний үгээр бичигдсэн гэж ойлгож болно. Ер нь Монголын хүүхдийн жүжгийг хэн найруулан тавьж байна вэ гэвэл Б.Хишигзаяа гэж хэлэхэд нэг их буруудахааргүй болсон. Ертөнц хэрхэн үүссэн талаар тайлбарласан өөрийн уран зохиолтой үндэстэн их цөөхөн. Манай Монголын уран зохиол хэр эртнийх, хэр хөгжсөн бэ гэдийн нэг илрэл нь аман зохиол юм. Аман зохиолын өчүүхэн нэг хэсэг нь тайзан дээр амилж байна. Үр хүүхдээ дагуулан ирж театрт цаг гаруй хугацааг өнгөрөөх нь таны амьдралд мартагдашгүй үдэш байх болно гэж эцэг, эхчүүдэд зөвлөмөөр байна” гэсэн юм. Мөн энэхүү жүжигт залуу жүжигчид оролцон тоглосон гэдгээрээ онцлогтой болсон гэдгийг онцолж байв. Жүжиг энэ сарын 5-наас эхлэн тоглох бөгөөд тасалбарын үнэ 8000 төгрөг юм байна.

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр -12
Шөнө -24

Нөгөөдөр
Өдөр -5
Шөнө -23

## Өдрийн зурхай

**ӨВЛИЙН АДАГ ЦАГААГЧИН ҮХЭР САР ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ ЦАГААГЧИН ТАХИА ӨДӨР**

**Наран ургах шингэх:** 08.17-17.55

**Үс засуулбал:** Хэл ам,хэрүүл тэмцэл ирнэ



*Тухайн өдөр хонь, бич, тахиа, могой, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд зэрэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Агтаг лугаа золгох, авшиг авах, ус гатлах, угаах зэрэгт сайн. Баруун нүд татвал садан ирэх, зүүн нүд татвал баярлах, баруун чих хангинавал гутамшиг болох, зүүн хангинавал завхарсныг сонсож цочих, бие татвал өмнө зүгээс зочин ирэх, хөл татвал хэрүүл гомдол болно. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой.*

## “Тэнгис” бэлгийн карт худалдаанд гарлаа

Тун удахгүй монгол түмний баяр цагаан сар болох гэж байна. Хүн бүхэн л шинэхэн дээлээ бэлтгэж, идээ будаагаа зэхэж байна. Бас хүүхдүүдийнхээ гарыг цайлгах бэлгийг хүртэл бэлдэж буй. Тэгвэл эрхэм танд санал болгох эгэлгүй нэгэн бэлэг байна. Үндэсний үйлдвэрлэлээ дэмжиж буй өнөө цагт яг тохирсон бэлэг гэвэл үүнийг л хэлэх байх. Тэр бол "Кино үзэх бэлгийн карт". Өхөөрдөм хөөрхөн үрсийнхээ оюуны алжаалыг тайлж, цагаан сараар кино үзэх эрхийн бичиг бэлэглээрэй. Та бүхэн сар шинэдээ сайхан шинэлээрэй. Төсөөллөөс илүүг Тэнгисээс...





## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Тендер шалгаруулалтын нэр:** Худалдааны гудамжны төгсгөлийн хэсгийн тохижилт
**Тендер шалгаруулалтын дугаар:** OP-39/2017
**Огноо:** 2017-02-03

Орхон аймгийн засаг даргын тамгын газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос Худалдааны гудамжны төгсгөлийн хэсгийн тохижилт ажил–ыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь 100,000 /нэг зуун мянган/ төгрөгөөр худалдан авч болно.

Тендерийн баримт бичгийн үнийг доорхи дансаар тушаана.

Төрийн сан 9025
**Дансны дугаар:** 100210051424
**Хүлээн авагч:**OP.OHӨГ нэмэлт санхүүжилт

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

**Үүнд:**

Санал болгож буй үнийн дүнгийн 50 хувьтай тэмцэх хэмжээний түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон зээл авах боломжтой байх

2015, 2016 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх

Дараах тусгай зөвшөөрөлтэй байх: Үүнд: Тусгай зөвшөөрөл: 2.1.1

Тендерийн хамт санал болгож буй үнийн дүнгийн [1%] төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 03 дугаар сарын 06-ний өдрийн 08 цаг 30 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 03 дугаар сарын 06-ний өдрийн 09 цаг 00 минутанд нээнэ.

**Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.**
**Дотоодын давуу эрх тооцно.**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**Орхон аймгийн ЗДТГ, Нутгийн удирдлагын ордон 1 давхар 113 тоот өрөө Утас:70358570**

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Тендер шалгаруулалтын нэр:** БОЭТөвийн Гэмтлийн тасгийн засварын ажил
**Тендер шалгаруулалтын дугаар:** OP-32/2017
**Огноо:** 2017-02-03

Орхон аймгийн засаг даргын тамгын газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос БОЭТөвийн Гэмтлийн тасгийн засварын ажил–ыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь 100,000 /нэг зуун мянган/ төгрөгөөр худалдан авч болно.

Тендерийн баримт бичгийн үнийг доорхи дансаар тушаана.

Төрийн сан 9025
Дансны дугаар: 100210051424
Хүлээн авагч:OP.OHӨГ нэмэлт санхүүжилт

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

**Үүнд:**

Санал болгож буй үнийн дүнгийн 50 хувьтай тэмцэх хэмжээний түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон зээл авах боломжтой байх

2015, 2016 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх

Дараах тусгай зөвшөөрөлтэй байх: Үүнд: Тусгай зөвшөөрөл: 2.1.1, 2.2.1

Тендерийн хамт санал болгож буй үнийн дүнгийн [1%] төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 03 дугаар сарын 06-ний өдрийн 08 цаг 30 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 03 дугаар сарын 06-ний өдрийн 09 цаг 00 минутанд нээнэ.

**Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.**
**Дотоодын давуу эрх тооцно.**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**Орхон аймгийн ЗДТГ, Нутгийн удирдлагын ордон 1 давхар 113 тоот өрөө Утас:70358570**

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2017 оны 02 дугаар сарын 03-ны өдөр
**Тендер шалгаруулалтын нэр:** Гэнэтийн аюул, ослын улмаас орон гэргүй болсон иргэд, бүтэн өнчин болон тэнэмэл амьдралтай иргэдэд гэр худалдаж авах
**Тендер шалгаруулалтын дугаар:** OP-111/2017

Орхон аймгийн ЗДТГ эрх бүхий тендерт оролцогчдоос Гэнэтийн аюул, ослын улмаас орон гэргүй болсон иргэд, бүтэн өнчин болон тэнэмэл амьдралтай иргэдэд гэр худалдаж авах тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь 50,000 /тавин мянган/ төгрөгөөр худалдан авч болно.

Тендерийн баримт бичгийн үнийг доорхи дансаар тушаана.

Төрийн сан 9025
**Дансны дугаар:** 100210051424
**Хүлээн авагч:** OP.OHӨГ нэмэлт санхүүжилт

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерийн хамт санал болгож буй үнийн дүнгийн [1%] төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 03 дугаар сарын 06-ний өдрийн 08 цаг 30 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 03 дугаар сарын 06-ний өдрийн 09 цаг 00 минутанд нээнэ.

**Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.**
**Дотоодын давуу эрх тооцно.**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**Орхон аймгийн ЗДТГ, Нутгийн удирдлагын ордон 1 давхар 113 тоот өрөө Утас:70358570**